

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Мянгатын Осоржамц	Дугаар	L071
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Хэрлэн сум
Төрсөн газар	Өвөр Монгол	Төрсөн он	1930
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хэрлэнбаяны хийд	Сүм хийдийн дугаар	ДОСР 023
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 26	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Сэргэлэн сумын Хэрлэнбаяны хийд

-Та өөрийн мэдэх сүм хийдийн тухай ярина уу?

Би чинь одоо Өвөрмонголд төрсөн. Өвөрмонголоос 15-тай энд орж ирсэн. Өвөрмонголд 5 настайдаа Зүүн Үзэмчний 6 хийдийн нэг Ламын сүм гэдэг газар 10 жил суусан. Сурсан юм нэг ч байхгүй. Хоолыг нь идсэн. Яахав дээ энд 45 онд ирээд хийдэд суусан ч юм байхгүй. Томоотой тохитой ч юм байгаа ч үгүй. Тэгээд цэрэг цуухт яваад. Явсаар байтал 19 58 оны намар Хэрлэнбаяны хийд гэдгийг татан буулгаад Гандан руу аваад явсан. Тэнд 3 хүн дагаж явсан. Багш лам Галсанравжаа, Дамбаа да лам гэдэг хүн дагаж явсан. Хэрлэнбаяны хийд гэж наад Сэргэлэнгийн 2-р бригадын төвийн баруун хойхно Баруунбаяны урд , голын баруунд байсан. Одоо сахиус энэ тэр нь байдаг ч юм уу. Тэр үед яг юуг Ганданд нийлүүлснийг Чойжиннямаа гэдэг хүн сайн мэднэ. Тэр ед чинь би хар нэртэй явсан. Энд ирээд 36 хийд нэгдээд 6 хийд байсан. Нэг хийд болсон. Гэр дугантай байсан. Үлдсэн лам нарыг нь хар болгоод.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хэрлэнбаяны хийдэд хэдэн лам хурж байсан бэ?

Эхлээд 50,60 сүүлдээ 20,30 болсон байх аа.

-Тухайн үед хийдийг хэн гэдэг хүн удирдаж байсан бэ?

Бид чинь багш лам л гэхээс нэрийг нь мэдэхгүй.

-Тэр үед урдаас ирэхэд үзэмчин 13 хувилгаантай ирсэн. Хувилгаан лам нар, ширээ лам нар.

-Хаанаас тодруулсан хувилгаан бэ?

Бүр баруун газраас тодруулсан.Банчэн богд, Далай лам нар тодруулж байсан. Тэрнээс биш манай тэнд чинь зүгээр нэг ном мэддэг гавжийн, дооромбо, лхаарамба мяндаг хийсэн хүнийг зүгээр нэг эрдэмтэн л гэхээс биш хувилгаан гэ үзэхгүй шүү дээ.

-Тэр 13 хувилгаан нь юу гэж юу гэж алдаршсан хувилгаадууд байсан юм бол доо.

Тэрийг байсан мэдэхгүй байна.

-Энд яг хэдэн онд хурж эхэлсэн бэ?

1945 онд ирснээсээ хойш анх өвөл нь Зүүн урд Халх голын урд Сүрийн манханд бөөгнөрсөн болж байсан. 1946 оноос эхэлсэн байх л даа. Тэгээд 1958 он хүртэл байсан.

Хэдэн дугантай байсан?

Том жижиг хоёр гэр дугантай байсан.

-Төвд нэрийг нь санаж байна уу?

Эндхийн нэрийг мэдэхгүй байна. Зүүн үзэмчний 6 хийдийн аль нэгийн нэрээр л нэрлэсэн байх даа.

-Танд тэр хувилгаадын зураг байна уу?

Надад 6 зураг л байгаа.

-Ямар хурал ном хурдаг байсан бол?

Цогчинтой байсан. Сарын 29,15,16,2-д хуралтай байсан. 16-нд Цагаан өвгөнөө тахидаг байсан. Шинийн 2-нд сахиус тахидаг байсан.

-Ямар сахиустай байсан бэ?

Сахиус нь Гомбо, Лхам хоёр байсан.